

О.Мөнхбат*МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологийн ухааны доктор (PhD)*

МОНГОЛ ДАХЬ БАЯЛГИЙН “НАЦИОНАЛИЗМ”: ТӨЛӨВ БАЙДАЛ, ҮЕ ШАТ

Abstract: *In the paper titled as “Resource nationalism in Mongolia: its character and specific” the author gives definition to resource nationalism as constitutional, natural right of citizen to have benefits from national resources located in their territory. The author analyzes and classifies resource nationalism in Mongolian with three stages in accordance with time framework from 1990-s to current days. Despite huge “brain washing” from transnational capital, corrupted politicians and media, resource nationalism became the part of national conscience and dignity of Mongolians, the author concluded.*

Key words: *Mongolia, resource nationalism, transnational capital, national conscience.*

Оршлын оронд

XX зууны төгсгөл үеэс уул уурхай, газрын баялгаас олж байгаа ашиг орлогын хуваарилалттай холбогдон баялгийн “национализм” хэмээх ойлголт бий болж улмаар зөвхөн эдийн засаг төдийгүй засаглал улс төр, улс хоорондын харилцааны “глобал” үзэгдэл болж хувирлаа. Анхлан байгалийн баялгаасаа ахиу хувь хүртэх, үндэсний засгийн газрын оролцоог нэмэгдүүлж үндэстэн дамнасан корпорацуудын эдийн засгийн эрх мэдэл, нөлөөллийг бууруулах эдийн засгийн зорилгоор үүсч цөөн тооны улс орныг хамарч байсан энэхүү үзэгдэл эдүгээ үндэсний эдийн засгаа бэхжүүлж, ард иргэдийн аж амьдралыг өөд татах, ядуурал, авлигыг бууруулах гэсэн нийгмийн чиг баримжаалалтай болж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хангахад чиглэсэн улстөрийн бодлогын өнгө аясыг олж, байгалийн асар их баялагтай атлаа ядууралд нэрвэгдсэн, буурай болон хөгжиж байгаа олон арван улс орнуудыг хамарч байна.

Баялгийн национализм¹ гэсэн энэхүү нэр томъёог анхлан уул уурхайн үндэстэн дамнасан корпорацын эрх ашгийг илэрхийлдэг олон улсын бизнесийн холбоод, тэдэнд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг консалтингийн пүүсүүд хэрэглэж эхэлжээ. Хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй улс орнуудад дарамт үзүүлэх замаар тэдний баялгийг хөрөнгө оруулалт, татварын хамгийн таатай нөхцөлөөр олборлох, шаардлагатай үед үндэсний эрх баригчид, улс төрчдийг авлигандан хахуульдах замаар “тогтвортой байдлын гэрээ” зэрэг хагас луйвар, хагас дээрмийн хэлбэрээр өндөр орлого, хариуцлага багатайгаар богино хугацаанд баялгийг цөлмөх бодлого хэрэгжүүлж ирсэн эдгээр корпораци, пүүс компанийн хувьд баялгаа хянах, орлогын дахин хуваарилалтыг санал болгосон аливаа үүсгэл санаачлага “аюул” дагуулж байсан тул дэлхийн олон нийтэд сөрөг утгаараа танил болсон национализм хэмээх энэхүү нэр томъёог хэрэглэсэн байна.

Нийгэм хүмүүнлэгийн ухаанд “национализм” буюу үндсэрхэг үзэл гэсэн ухагдахууныг ихэвчлэн сөрөг шүүмжлэлт утгаар нь авч тайлбарлаж ирсний сацуу хүн төрөлхтний түүхэнд үндсэрхэг үзлээс үүдэлтэй цөөнгүй дайн хямрал, мөргөлдөөн, яс үндсээр ялгаварлан хоморголон устгах зэрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүд өдөөж цусан мөр үлдээсэн нь бий. Хэдийгээр М.Веберын хэлсэнчлэн модернизм, рациональ сэтгэлгээ хөгжин дэвших тусам хүмүүс, улс хоорондын харилцаанд яс үндэс зэрэг овгийн байгууллын тодорхойлогч хүчин зүйлс нөлөөллөө алдаж, эдийн засгийн харилцан ашигтай байх зарчим, ашиг сонирхол зэрэг орчин цагийн хөдөлгөгч хүчинд байраа тавьж өгч, национализмын ач холбогдол буурч байгаа боловч улстөрийн тодорхой нөхцөл байдлаас үүдэн хурцаар илрэх тохиолдол байсаар байна. (Weber.M, 1958)

Хамгийн сүүлд гэхэд л Европын цээжнээ орших Югослав улс задрах явцад Серб болон Боснийн мусульмануудын хооронд өрнөсөн цуст аллагаас үүдэн олон арван мянган иргэд амь

¹ (Англиар: resource nationalism, Оросоор: национализм природных богатств)

насаа алдсан бол өрнөдийн ардчиллын тэргүүлэгч орнуудын нэг Канад улсын франц үндэстэн оршин суудаг Квебек муж англи саксонууд голлон амьдардаг Канадын хэсгээс салан тусгаарлаж өөрийн бие даасан улсаа байгуулах оролдлого хийсээр байгааг энд дурдаж болох юм. (Cornel.S and Hartman.D, 2007)

Уламжлалт “национализм”-аас жийрхдэг хүмүүсийн тогтсон хэв шинж (stereotype) дээр тоглолт хийх замаар Баялгийн “национализм” бол эдийн засаг хямралд хүргэж, ажилгүйдэл, ядуурлыг хөөргөдөн улс төрийн хямралд хүргэх сөрөг үр дагавартай хэмээн зарим судлаачид ярьж байгаа нь ард иргэд, улс орон өөрийн баялгаасаа шударгаар хувь хүртэх эрхийг хаан боогдуулах, баялгийг хямдаар авах том капиталын эрмэлзлэлийг хамгаалсан, бусдын тархийг угаах үйлдэл хэмээн үзэж болох юм. (Bremer.I, 2010) and (Domjau.D, Volume 62, Issue 1, 2010) Алтны гэнэтийн ашгийн татвар ноогдуулах, Оюултолгойн гэрээ, Ашигт малтмалын хуульд өөрчлөлт оруулах болон стратегийн орд газруудад тогтоох төрийн хяналт зэрэг байгалийн баялгийн хуваарилалтанд ард иргэд, засгийн газрын оролцоо, хувь эзэмшлийг нэмэгдүүлэх гэсэн бодлого бүрийг гадаадын хөрөнгө оруулалт Монголоос зугтана, Монгол улсын нэр хүнд унаж, олон улсын итгэлцлэл буурна гэх зэргээр айлгах, дарамт үзүүлэх оролдлогууд байсаар байгаа нь чухамдаа дээрх тоглолтын салшгүй хэсэг, нэг найруулга, жороор явж буй зүйл юм. Чухамдаа сонгодог болон баялгийн национализмын хооронд асар их ялгаа байгаа юм. Үүний тулд энэ хоёр үзэгдлийн тодорхойлолтыг харьцуулан үзье.

Национализм буюу үндсэрхэг үзлийг эрдэмтэд тодорхойлохдоо 1. Яс үндэсний адилсал (ethnic identity), 2. Бие даасан/тусгаар тогтносон байдал (sovereignty), 3. хамтын амьдрал (peoplehood) гэсэн үндсэн шинжүүдийг ойлгож, хуульчлан хүлээн зөвшөөрч, түгээн тархаах нөхцөлийг хэлнэ гэж үзэх нь түгээмэл байдаг. (Cornel.S and Hartman.D, 2007). Өөрөөр хэлбэл, национализмын тулгуур үндэс бол а) бие даасан байдал, б) адилсал в,) нэгдэл гэсэн чандмалсан гурван ойлголт хэмээн үзэж болох ажээ.

Харин баялгийн национализм бол “уламжлалт” национализмаас 1.Тусгаар улс болох шаардлагыг агуулаагүй буюу нэгэнт тусгаар тогтносон улс орны түвшинд явагддаг, 2.Нэг үндэстэн ястан нөгөөгийн эсрэг хандаагүй эсвэл заавал нэг ястан үндэстэнд харьялалалтай байхыг шаарддаггүй буюу үндэстэн ястны шинж чанарыг агуулаагүй, 3.Байгалийн баялагтай улс орны төр засаг, ард иргэдийн зүгээс үндэстэн дамнасан корпораци, гадаадын хөрөнгө оруулалттай үндэсний компани, түүнчлэн олборлолт эрхэлдэг үндэсний компанийн эсрэг хандсан зэрэг шинж чанараараа ялгаатай нийгмийн үзэгдэл юм. Энэ утгаараа баялгийн национализм бол ард иргэд, улс орон өөртөө заяасан баялгийн олборлолт, олж байгаа орлогод хяналт тогтоохыг эрмэлзсэн эрмэлзэл ажээ. (wikipedia.org, 2012)

Баялгийн “национализм” гэдгийн дор улс орон, ард иргэд өөрийн нутаг дэвсгэрт байгаа аливаа баялаг түүний дотор хөрсөн доорх нефть, хий гэх мэт шингэн болон алт, зэс, нүүрс зэрэг хатуулаг, металл баялгийг гадаадын хөрөнгө оруулалтын оролцоотойгоор олборлон олж байгаа орлогын тодорхой хувийг /ихэвчлэн дийлэнх хувь/ хувьцааны хяналтын багцыг төрийн мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэн авах, нөөц ашигласны төлбөр, орлогын татвар оноох зэрэг олон арга хэлбэрээр эх орондоо авч үлдэх эрмэлзэл буюу шударгаар хувь эзэмших жам ёсны эрх хэмээн ойлгох ёстой билээ.

Бусад улс орнуудын нөхцөл байдал:

Баялгийн “национализм” ХХ зууны сүүлчээ Латин Америкийн улс орнуудад хүчээ авч эхэлсэн бөгөөд аажмаар Ази, Африк, Европын зарим улс орнуудад тархаж, ХХI зууны “үндэстэн дамнасан”, глобал үзэгдэл болон өргөжиж байна.

Латин Америкийн улс орнуудаас жишээлэхэд, Венесуэлын засгийн газраас Еххон, ConocoPhillips, BP and Norway’s Statoil зэрэг нефть, хийн олборлолт явуулдаг үндэстэн дамнасан корпорациудаас хувьцааны хяналтын багцаа төрийн мэдэлд шилжүүлэх, эсвэл тус улсаас хөрөнгө оруулалтаа татаж, гарахыг шаардсан бөгөөд Еххон, ConocoPhillips хөрөнгөө татаж гарснаас улбаалан зөвхөн ConocoPhillips нийт орлогынхоо 94 орчим хувийг алдаж, дампуурлын ирмэгт тулжээ. (Johnson.T, 2012)

Перу, Чили улсуудын тухайд байгалийн баялгийн борлуулалтанд 1-3 хувийн татвар ноогдуулах шийдвэр гаргасан бол Боливи хийн олборлолтыг 2016 гэхэд улсын мэдэлд бүрэн авахаар шийдсэн байна.

Ази тивийн тухайд Индонези улс уул уурхайн бүтээгдэхүүнд борлуулалтын татвар ноогдуулах шийдвэр гаргасан бол зөвлөлтийн дараах улсуудын нэг Киргизстаны засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалт бүхий уул уурхайн зарим компанид олгосон лицензийг

эргүүлэн хураах шийдвэр гаргаж харин манай хойд хөрш ОХУ Стратегийн орд газруудад гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлахаар болжээ.

Түүнчлэн ядуурлын түвшин, эрх баригчдын авлига хээл хахуульд идэгдсэн үзүүлэлтээрээ дэлхийд “толгой цохидог” Африк тивийн улс орнуудын хувьд мөн л баялгийн хуваарилалтыг шударга болгох, түүнээс орох орлогыг нэмэгдүүлэх үүднээс нэлээдгүй чанга шийдвэрийг батлах улс төрийн хүсэл зоригийг гаргасан байна. Тухайлбал, Намиби уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтанд 5 хувийн татвар ноогдуулахаар шийдвэрлэсэн нь энэ төрлийн татварын хамгийн дээд хэмжээ болсон бөгөөд Өмнөд Африк алтны борлуулалтанд 3 хувийн татвар ноогдуулахаар хууль журмандаа өөрчлөлт оруулсан ажээ. Түүнчлэн Зимбабве уул уурхайн компаниудад өөрсдийн хувьцааны хяналтын багц буюу 51 хувийг төрийн мэдэлд шилжүүлэх шаардлагыг хүргүүлж, Венесуэл улсын туршлагыг давтжээ. (Gorbansky.A, 27 Sep, 2006)

Монголын нийгмийн нөхцөл байдал:

Баялгийн олборлолт, түүнээс олж байгаа ашиг орлогыг хянахад ард олон, үндэсний төр засгийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн Монгол улс, Монголчуудын хүсэл эрмэлзэл ХХ зууны төгсгөл, ХХI зууны эхэн үе хүртэл уналт бууралт, өсөлт идэвхжил зэрэг харилцан адилгүй үе шатыг дамжин иржээ.

Социалист Монгол улс хорьдугаар зууны турш ЗХУ тэргүүтэй Эдийн засгийн харилцан туслалцах Хамтын нөхөрлөлийн (ЭЗХТХН) гишүүн коммунист орнуудын бүрэн хяналт, хөрөнгө оруулалтын дор өөрсдийн байгалийн баялгийг олборлож, ашиглаж ирсэн бөгөөд ах дүүгийн найрамдалт харилцаа, социалист лагерийн орнуудын хамтын ажиллагаа нэрийн дор “ямар ч хэл үггүй” явсаар 1990 –ээд онтой золгожээ. 90 ээд оны эхэн үеийн Зөвлөлтийн эсрэг үзлийн идэвхжилийн багахан хугацаанд Эрдэнэт, Мардай зэрэг цөөн хэдэн уурхайн талаар “бага сага үг хэл” гаргасан ч тэгсхийгээд намжсан аж.

Зах зээлийн нийгэмтэй золгосон 1990 оноос өнөөг хүртэл Монголчуудын баялгийн “национализм”-ын үүсэл, өрнөлийг дараах байдлаар томъёолж болох юм.

1990 оны эхэн, дунд үе:

Баялгийн национализмын үр хөврөлийн үе: Энэ үе шилжилтийн хамгийн бэрх цаг хугацаатай давхцаж байгаа бөгөөд улс орны эдийн засаг сүйрлийн байдалд орж, төсвийн 70 гаруй хувийг хандивлагч орнуудын тусламж дэмжлэгээр бүрдүүлж байлаа. Үндэсний үйлдвэрлэл бүхэлдээ зогсож, ядуурал, ажилгүйдэл, мөнгөний ханшны уналт, үнийн өсөлт гаарсан, дийлэнх Монголчуудын хувьд “дээшээ тэнгэр хол доошоо газар хатуу” гэгч болсон үе байлаа. Хэдийгээр асар их байгалийн баялагтай авч түүнээ ашиглах техник технологи, дэд бүтэц байхгүй, үндэсний зарим харалган улс төрч, судлаачид “алт сандайлсан гуйлгачин”, “Монгол биеэ үнэлэх сайхан хүүхэн биш” зэргээр улс орноо ад үзэн хийрхэж байлаа. Гэсэн хэдий ч нийт ард олны санал бодолд улс орныхоо гэрэлт ирээдүйд итгэсэн өөдрөг үзэл өндөр хувьтай байж, гадаадын хөрөнгө оруулалт бүрийг энэ ирээдүйд ойртуулж байгаа боломж хэмээн үзэж байв. Түүнчлэн иргэдийнхээ энэ итгэл найдвар дээр төрийн эрх барьж байсан хүмүүс популист тоглолт хийж, тархи угаалтыг ямар ч эрээ цээргүй хийж байсан нь улсын маань ерөнхийлөгч хүртэл Хятадын хөрөнгө оруулалттай компаний газрын тосны цооногноос асарсан шаарнаас төрийн хүндэтгэлийн дээлэндээ нялж, бид өөрийн нефттэй боллоо хэмээн хөөрцөглөсөн инээдэмтэй, хөөрхийлэлттэй дүр зургаас харагдаж байлаа. Гадаадынх бол юуг ч хүлээн зөвшөөрч, гар дэлгэн тэвэрч авч байсан энэ үед баялгаа хайрлах хамгаалах, үр шимийг нь ард олондоо хүргэх бодлого, сэтгэл тэр үеийн эрх баригчдад байсангүй бөгөөд цөөн эрх мэдэлтэн, бизнесменийг хөлжүүлсэн “Алт” хөтөлбөрийг үндэсний сэргэн мандалтын хэмжээнд өргөмжлөн зарлаж байлаа. Чухам тэгэхэд жижиг буурай улсын баялгийг “Тогтвортой байдлын гэрээ” нэрээр авлигажсан эрх баригчидтай нь хавсайдан хэрхэн үнэ төлбөргүй цөлмөж болдгийг сонгодог байдлаар харуулсан Бороо гоулд мэтийн компаниудын алтан үе эхэлжээ. Энэ үед сөрөг хүчингүй нам-төрийн хязгааргүй ноёрхол эргэн бэхжиж, иргэдийн эрх ашиг, эрхийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагууд ч бүрэлдээгүй байсан тул байгалийн баялгаас ард иргэд хүртэх тухай яриа ч сонсогддоггүй, баялгийн национализмын сураг ч байгаагүй тийм үе байлаа.

1990 оны төгсгөл 2000 оны эхэн, дунд үе:

Баялгийн национализм эрчимжилт: Ард иргэд Газрын тос, Алт хөтөлбөрүүдэд итгэл алдарч, эрх мэдэлтэй цөөнх нь хэрхэн баяжиж байгааг харсан олон нийтийн бухимдал нэмэгдэж байсан үе юм. Энэ үед байгаль орчны бохирдол нэмэгдэж, лицензийн наймаа гаарч, гадаадын

хөрөнгө оруулагчид эрх мэдэлтнүүд үгсэн хуйвалдах, авлига хээл хахуулийн эрчимжилт, адуурал улам бүр нэмэгдэж, Монголын гурван хүн тутмын нэг нь ядуу гэсэн ангилалд оржээ.

Гэсэн хэдий ч ард иргэд баялгаа ашиглаж хөгжих ёстой гэсэн итгэл өндөр хэвээр байсныг тухайн үед явуулсан судалгаа шинжилгээний дүнгээс харагддаг. Тухайлбал, Полиси төвөөс 2006 онд хийсэн судалгаанд хамрагдсан 1500 иргэний 88,3 хувь нь Монгол улс “Газрын баялгаа ашиглаж, уул уурхайг түшин хөгжих ёстой гэж үзэж байсан бол дөнгөж 9,5 хувь үүнтэй санал нийлээгүй байна. (Полиси, 2006)

Энэ үеэс Монголчуудын дотор баялгаа ард иргэдийн сайн сайхны төлөө ашиглахгүй байна гэсэн үзэл эрчимжиж эхэлсэн нь, уул уурхай одоогийн байдал улс орны хөгжилд эерэг нөлөөлөл авчрахгүй буйн шалтгааныг нийт респондентын 22,7 хувь нь баялгаа гадагшаа ямар ч татваргүй зөөж байгаа явдал гэсэн бол Монгол хүн баялгаасаа хувь хүртэхгүй байна гэж 19,0 хувь нь тайлбарласнаас харагдаж байна. (Полиси, 2006)

Түүнчлэн Оюутолгойн ордыг тойрсон яриа шүүмж ид өрнөж эхэлсэн бөгөөд ард иргэдийн дотор зөвхөн ажилтай болж орлого олохоос гадна улс орны хөгжилд ийм том ордын гүйцэтгэх үүргийг ултай суурьтай үнэлж үзэх болсон нь өөр бусад судалгаанаас илт харагддаг. Жишээ нь МУИС-ийн Нийгмийн судалгааны Хүрээлэнгээс 2007 онд явуулсан “Оюутолгой төслийн орон нутгийн хөгжилд үзүүлэх нийгэм эдийн засгийн үр нөлөө” сэдэвт судалгаанд оролцогчид Оюу толгой төсөл хэрэгжсэнээр Монголын говьд Эрдэнэт шиг том хот байгуулагдах ёстой гээд гол хариуцлага, хөрөнгийг Оюу толгой майнз компани үүрэх ёстой хэмээн үзэж байлаа.

Монголын газар нутаг дээр үйл ажиллагаа явуулж ашиг олж байгаа учраас Айвенхоу

Майнз бүх хөрөнгө оруулалтыг хийх ёстой.

Чанарын судалгаа. Хөвсгөлийн харьяат. Эрэгтэй. 36 настай

Монголын засгийн газар бодлогын зохицуулалт хийж, газрын баялгийг нь ашиглаж хүмүүсийг нь ажиллуулж байгаа учраас хүмүүсийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэх үүргийнхээ дагуу Айвенхоу Майнз компани бүх хөрөнгийг гаргах ёстой.

Арилцлага, Даланзадгадын харьяат. Эмэгтэй. 23 настай. (МУИС, 2008)

Түүнчлэн тэр үед байгалийн баялгийн хуваарилалт, байгаль орчинд учруулж байгаа хор хөнөөл, лицензийн наймаа зэрэг хууль бус үйлдлүүдийг ярьдаг хэлдэг иргэний нийгмийн байгууллагууд, ТББ –ууд нэмэгдэж, үйл ажиллагааны чиглэл нь нарийвчлагдаж эхэлсэнээр олон нийтийг соён гэгээрүүлэх, тэдний анхаарлыг татах зэрэг баялгийн национализм идэвхжих хөрс суурь бүрдэхэд эергээр нөлөөлөв. Тухайн үед манай улсад улсын бүртгэлтэй нийт 5000 гаруй ТББ, иргэний нийгмийн байгууллага байжээ. (Мөнхбат.О, 2007)

Мөн төр засгийн зүгээс баялагтаа хяналт тавих, хууль эрх зүйн орчноо боловсронгуй болгох зэрэг оролдлогууд хийгдэж эхэлсэн бөгөөд Таван толгойн хувьцааг улс буцаан худалдаж авах, 2007 онд УИХ-аас “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоол батлах зэрэг бодлогын болон практик арга хэмжээ эрчимжиж ирсэн нь харагддаг. (УИХ, 2012)

2000 оны төгсгөлөөс өнөөг хүртэл:

- **Баялгийн национализмын хүчирхэгжилт:** Энэ үе бол баялгийн тэгш бус хуваарилалт гаарсан, авлига хээл хахууль институцилэгдсэн, эдийн засаг-улстөрийн олигарх бүлгүүдийн ноёрхол тогтсон төдийгүй тэдгээрийн хоорондын тэмцэл хурцдаж эхэлсэн үе юм. МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэнгээс 2009 онд Азийн судалгааны төвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Монгол дахь улс төрийн эдийн засгийн бүлэглэлүүд” төслийн хүрээнд ТББ-ын (200 хүн) болон Төрийн албан хаагч (423 хүн) нийт 623 хүний дунд явуулсан судалгаанаас үзэхэд:

Монголын төр засгийг олигарх бүлэглэлүүд бүрэн хянадаг гэсэнтэй санал бүрэн нийлнэ гэж ТББ –ын 40,9 хувь, төрийн байгууллагын 41,0 хувь, зарим талаар нийлнэ гэж 41,9 хувь, 37,9 хувь үзсэн бол санал нийлэхгүй гэж дөнгөж 7,6 хувь, 12,1 хувь тус тус хариулжээ. Харин хөдөө орон нутагт орон нутгийн шинжтэй олигарх бүлэглэлүүд аль хэдийн үүссэн гэж ТББ –ын 62,8 хувь, төрийн байгууллагын ажилтнуудын 52,9 үзсэн бол одоо үүсч байгаа гэж 26,1%, 30,7% тус тус үзжээ. (Хүрээлэн, 2010)

Оюутолгойн гэрээнд Засгийн газар гарын үсэг зурж, УИХ батламжилсанаар Монголын тал 34 хүрэхгүй хувийг эзэмших болж, урьдчилгаа болгон авсан өндөр хүүтэй зээлээ эрх баригчид хүний хөгжлийн мөнгө нэрээр тараах болсон нь нийгмийн идэвхтэй хэсэг, улс төрийн

сөрөг хүчнүүд, иргэний нийгмийн хөдөлгөөний бухимдлыг төрүүлж, улмаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч ихээхэн анхаарал хандуулж эхэлсэн онцлогтой байлаа. Энэ үеэс лиценз олголтонд хяналт тавих, хууль бусаар олгосон заримыг нь хурааж, хүчингүй болгох уриалга хүчтэй сонсогдох боллоо. 2000 оны төгсгөлөөр лиценз олголт ямар байдалтай байсныг дараах судалгаа харуулдаг. Нээлттэй Нийгэм Форумгаас явуулсан Лиценз ажиглагч судалгаанаас харахад

2009 оны 7 дугаар сарын 07-ны байдлаар Монгол улсад 5200 хүчинтэй уул уурхайн олборлолтын болон бусад лиценз олгогдсоноос зөвхөн 2008 онд нийт лицензийн тоо 767 –аар нэмэгдсэн бол 2009 оны 1-2 дугаар сард 132, 3-4 дүгээр сард 118 аар нэмэгдэж харин 8-9-10 дугаар сард 164 ширхэгээр өсчээ. (Форум, 2010)

Уул уурхай, ашигт малтмалын ашиглалтаас үүдэн байгаль орчны бохирдол асар нэмэгдэж, орон нутгийн иргэд өөрсдийн төрсөн газар орноо хамгаалах зорилгоор олон тооны ТББ –ууд байгуулан тэмцэж эхэлсэн явдал баялгийн национализм Улаанбаатар хотоос халин гарч хөдөө алс нутагт түгэн, жирийн нүүдэлчин малчдыг хүртэл хамарч нийт ард түмний үндэсний ухамсар сэргэсний илэрхийлэл болсон юм. Үүний зэрэгцээ ИНБ-ууд чадавхжсан, ард иргэдийн амьдралын чанарын тухай ойлголт өөрчлөгдөж, хоосон хонохгүй хоёр идэхгүй бол болж бүтэж байна гэсэн уламжлалт сэтгэлгээнээс татгалзаж, эрүүл саруул, аюулгүй амьдрах орчныг шаардах, амьжиргааны хэрэгцээ, хэрэглээ өөрчлөгдсөн зэрэг нь баялгийн национализмыг хүчирхэгжих таатай нөхцөлийг бүрдүүлжээ.

Түүнчлэн УИХ болон орон нутгийн сонгуультай холбогдон улс төрийн намуудын идэвх сэргэн сонгогч олны шаардлагад нийцсэн арга хэмжээ авахыг эрмэлзэх болсноос эрх баригчид байгальд нөхөшгүй хор хөнөөл учруулж болзошгүй орд газруудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоход чиглэсэн “урт нэртэй” хууль, улсын хөрөнгөөр хайгууль хийгдсэн орд газрын хяналтын багц, стратегийн орд газруудыг төрийн мэдэлд авах, гадаадын хөрөнгө оруулалтыг Засгийн газрын түвшинд шийдэх зэрэг цөөнгүй арга хэмжээ авсан нь Монголчуудын баялгийн национализмд эерэг үүрэг гүйцэтгэлээ.

Ийнхүү баялгийн “национализм” буюу өөрсдийн баялгаас шударгаар хувь хүртэх жам ёсны эрхээ эдлэхийг эрмэлзсэн эрмэлзэл Монголчуудын үндэсний ухамсрын бүрэлдэхүүн хэсэг болж байна. Хэдийгээр гадаадын том капитал болон ашиг сонирхлын зөрчилтэй эрх баригчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон ихийг мэдэгчийн дүр эсгэсэн эдийн засгийн шинжээчид дэлхий хямарч, байгалийн баялгийн үнэ цэнэ унаж байна, үүнээс урьтаад хямдхан ч атугай хурдан зараад авъя, гадаадын хөрнгө оруулагчид хөрөнгөө татвал Монгол улс балрах тул аль болох тэднийг аргадах, тойглох хэрэгтэй гэх мэтээр ард олны тархийг угаахыг эрмэлзэж байгаа ч жам ёсны эрхээ эдлэхээс татгалзах саруул ухаант Монгол хүн байхгүй бизээ.

Товч дүгнэхүй

- Баялгийн “национализм” бол хүн төрөлхтний сөрөг утгаар тайлбарлан үзэж, жийрхэж дадсан сонгодог национализм биш бөгөөд өөрсдийн эх орон эх нутагт заяасан байгалийн баялгаас шударгаар хувь хүртэх жам ёсны эрхээ эдлэхийг эрмэлзсэн буурай хөгжилтэй, хөгжиж байгаа орнуудын ард иргэд, үндэсний засгийн газрын эрмэлзэл юм.
- Латин Америкаас эхлэлээ авсан энэхүү эрмэлзэл улмаар Ази, Африк, Зүүн европын зарим орнууд хамарсан, үндэстэн дамнасан глобаль үзэгдэл болон хувирч, XXI зууны нэгэн онцлог болж байна.
- Монгол улс баялгийн национализмын тэг цэгээс асар идэвхжсэн, хүчирхэгжсэн үе болох эдүгээ цагийг хүрч, улмаар эл национализм ард олон, иргэний нийгмийн хөдөлгөөний хүрээнээс хальж, улс төрийн нам эвсэл, үндэсний засгийн газрын номлол болж байна.
- Баялгаа хурдхан, хямдхан зарах, гадаадын хөрөнгө оруулалтанд хамгийн таатай нөхцлийг бүрдүүлэхгүй бол Монгол улс үнсэнд хаягдсан шалз лугаа адил болж хувирна зэргээр олон улсын болон үндэсний том капиталд худалдагдсан улс төрчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд завсар зайгүй тархи угааж байгаа хэдий ч баялгийн “национализм” Монголчуудын үндэсний ухамсрын салшгүй хэсэг болжээ.
- Өвөг дээдсээс заяасан баялгаа ард иргэдийн сайн сайхны төлөө ухаалаг, шударга зарцуулж, улс орноо ядуурлаас гаргах асуудал бодлого, боловсруулагчид, үндэсний засгийн газрын өмнө тулгарч байгаа бөгөөд эс чадваас сонгогчдоос итгэн олгосон эрх мэдлийн өндөр сэнтийгээс хөөгдөн арчигдах буй бизээ.

Ашигласан ном зохиол

- Bremer, I. J. (2010). The Rise of and Fall of Resource nationalism. *Global Politics and Strategy*.
- Cornel, S and Hartman, D. (2007). *Ethnicity and Race. Making identities in a Changing World*. USA: Pine Forge Press.
- Domjau, D, S. (Volume 62, Issue 1, 2010). A Comparative Study of resource Nationalism in Russia and Kazakhtan 2004-2008. *Europe-Asia Studies*.
- Gorbansky, A. (27 Sep, 2006). Resource Nationalism: Challenges and Opportunities for Reserve Growth. *Denver Gold Forum*. Denver: Frontier Strategy Group.
- Johnson, T. (2012, Oct 10). *The return of Resource Nationalism*. www.cfr.org
- Weber, M. (1958). *Economy and Society*. Berkeley: University of California Press.
- wikipedia.org. (2012, Oct 10).
- Мөнхбат, О. (2007). *Төрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох нь*. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум.
- МУИС (2008). *Оюутолгой төслийн орон нутгийн хөгжилд үзүүлэх нийгэм эдийн засгийн үр нөлөө*. Улаанбаатар: МУИС.
- Полиси судалгааны төв. (2006). *Уул уурхай болон ард олны санал бодол*.
- УИХ. (2012, Oct 11). УИХ-ын 27 дугаар тогтоол Retrieved from: <http://www.legalinfo.mn>
- Форум, Н. Н. (2010, January 20). *Лиценз ажиглагч*. Retrieved from <http://www.forum.mn>
- Нийгмийн Судалгааны Хүрээлэн (2010). *Монголын нийгэм дэх улс төр эдийн засгийн олигарх бүлэглэлүүд*. Улаанбаатар: Азийн Судалгааны Төв.